

ТЕХНИКИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

ДЦС-2 ТӨХК-аас “Техникийн бодлогын баримт бичиг” боловсруулах эрх бүхий хувь хүн болон албан байгууллагыг урьж байна.

Үнийн санал ирүүлэх компани нь

1. Өмнө нь ижил төстэй судалгааны ажил хийсэн туршлагатай байх.
2. Боловсон хүчин нь дотоод, гадаадад судалгааны чиглэлээр боловсрол эзэмшсэн статистик анализ хийх чадвартай байх, эрчим хүчний чиглэлээр зөвлөх эсвэл мэргэшсэн инженертэй байх.

Ажлын даалгавар өгөх үндэслэл	<p>“Эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөр “Эрчим хүчний тухай хууль” “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль” “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)” “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг” Тус станцын ашиглалтын хугацааг уртасгах, шинэчлэх</p>
Ажлын зорилго, гарах үр дүн	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд одоо болон цаашид баримтлах зарчмыг тодорхойлох, мөрдөж ажиллахаар боловсруулна. ✓ Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахуйц үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах зэрэг арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх стратегийг боловсруулах ✓ Үйлдвэрлэлийн явцад гарч болох техникийн эрсдэлийг бууруулахад баримтлах зарчим, арга хэмжээг тусгасан байна
Ажлын хөтөлбөр	<p>Компанийн үндсэн ба туслах тоноглолын төлөв байдалд судалгаа, үнэлгээ хийж тулгамдаж буй асуудлыг тодорхойлох</p> <p>Цахилгаан станцын үндсэн болон туслах тоноглолуудын төлөв байдлыг үнэлсний үндсэн дээр тоноглолын шинэчлэл, үр ашгийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг томъёолох</p> <p>Сүүлийн жилүүдийн их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн ажлуудын дүн шинжилгээ, үр өгөөжийн судалгаа хийх</p> <p>Цаг үеийн, засварын, аваар сааталтай холбоотой өгөгдлийн сангийн баяжилт хийх</p> <p>Гадаад орны цахилгаан станцын хөгжлийн чиг хандлага, дотоодод хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар судалгаа боловсруулах</p> <p>Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан тус станцын техникийн талаар баримтлах урт хугацааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>Цахилгаан станцын үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагад баримтлах зарчим бодлогыг Аюулгүй байдал, Үр ашиг, Байгаль орчны тогтвортой байдал, Эрчим хүчний хүртээмжтэй</p>

	байдал, Үнийн тарифын боломжит байдал гэсэн үндсэн чиглэлийн дагуу боловсруулах
	Техникийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг чиглэл, үе шат бүрд тодорхойлох
	Захиалагчийн саналын дагуу нэмэлт боловсруулалт хийх
	Судалгаа, дүн шинжилгээний ажлын дүнг нэгтгэн санал зөвлөмж, тайлан боловсруулах
Хамтран ажиллах	Захиалагчийн зүгээс нэмэлт мэдээлэл гаргаж өгөх, газар дээр нь нэг бүрчлэн танилцуулах Бусад шаардлагатай мэдээллээр хангаж хамтран ажиллана
Зөвлөхөд учрах хүндрэл	Тоног төхөөрөмжүүд нь ихэвчлэн 1961, 1968 онд ашиглалтад орсон байх тул хүндрэл үүсэхээр байгаа болно
Мөрдөх хууль тогтоомж стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд	“Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг”
Тавигдах шаардлага, тусгай нөхцөл	Мэргэжлийн шийдлээр хандаж ойлголт мэдээллээ бүрэн гүйцэт авч, үнэлэн тайлбарлан бичиж ажиллана

Сонирхсон иргэн аж ахуйн нэгжүүд 2022 оны 07 сарын 04-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө tpp2@tpp2.energy.mn хаягаар үнийн санал, хугацаа, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын нотлох бичиг баримтыг ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДЦС-2 ТӨХК өөрийн байр, 109 тоот, Худалдан авах ажиллагааны хэсэг, Утас 70172157